



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/553

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "А", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 77 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан зарцуулсан халдвар хамгааллын хэрэгсэл, шатахууны зардалд 5 360 500, багаж, техник, хэрэгслийн засварын зардалд 7 050 000 төгрөг, нийт 12 410 500 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 12 410 500 төгрөг /арван хоёр сая дөрвөн зуун арван мянга таван зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөцөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Шүлхий өвчин гарсантай холбогдож гарсан халдвар хамгааллын хэрэгсэл, тээвэр шатахуун, багаж, техник, хэрэгслийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга /Д.Батцэнгэл/-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ